

ТӨЛБӨРИЙН ХҮСЭЛТ № 00600

2020 оны 12 сарын 24 өдөр

Байгууллагын нэр: Эрүүл мэндийн яам	Дансны дугаар	Дүн тоогоор
Регистрийн дугаар: 9087443	100900020001	
Хүлээн авагчийн нэр: Баянгол Мед ХХК	Дансны дугаар	
Регистрийн дугаар: 2869225		
Хүлээн авагчийн банк: Худалдаа Хөгжлийн Банк	475006054	448,560,000.00
Мөнгөн дүн үсгээр: Дөрвөн зуун дөчин найман сая таван зуун жаран мянган төгрөг	Ангилал	
Гүйлгээний утга: ЭМДТөв-д шаардлагатай тон.төх багц /Багц-3/ Г.Бат-эрдэнэ	71601 - Нийгмийн эрүүл мэнд 81605 - Эрүүл мэндийг дэмжих 0000 - Төрийн сан 210601 - Багаж, техник, хэрэгсэл	448,560,000.00

Хяналтын хуудас №: 00600

Үндэслэх бичиг баримтын нэр	Үндсэн баримтын он сар дугаар	Төрийн сангийн тэмдэглэл
1.Нэхэмжлэх	2020.12.18	
2.Зарлагын баримт	2020.12.18	
3.Техникийн комиссын урьдчилсан дүгнэлт №98/2020	2020.12.18	
4.ТНБД-ын Үнэлгээний хорооны тушаал А/86	2020.09.09	
5.Тендерийн үнэлгээний тайлан	ЭМЯ 2020/09/17	
6.Баянгол мед албан тоот №1219	2020.12.09	
7.Тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээ №364	2020.10.29	

Тамга

Дарга


Гарын үсэг

Нягтлан бодогч



Я.Амаржарагал

Э.Эрдэнэцэцэг



Төрийн санд гүйлгээ хийсэн

.....оны....сарын....өдөр

Тэмдэг, гарын үсэг

БАТЛАВ:



ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ТӨВД ШААРДЛАГАТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ,
/БАГЦ-№2 МЭДРЭЛИЙН ЭМГЭГИЙН ОНОШИЛГООНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ/
НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар № 364

Улаанбаатар хот

Нэг талаас “ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ” (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “БАЯНГОЛ МЕД” ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Эрүүл мэндийг дэмжих төвд шаардлагатай тоног төхөөрөмж Багц-№2: “Мэдрэлийн эмгэгийн оношилгооны тоног төхөөрөмж”-ийг нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг хүлээн зөвшөөрч гэрээ байгуулав. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг 448,560,000₮ /Дөрвөн зуун дөчин найман сая таван зуун жаран мянга/ төгрөгөөр Улсын төсвийн хөрөнгөөс санхүүжүүлнэ. 2020 онд санхүүжих дүн 448,560,000₮ /Дөрвөн зуун дөчин найман сая таван зуун жаран мянга/ төгрөгийг тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсний дараа нийлүүлэгчийн дансанд шилжүүлнэ.

4. Нийлүүлэгч нь доорх нэр төрлийн барааг, талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажсанаас хойш 45 хоногийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

№	Барааны нэр	Барааны гарал үүсэл	Марк	Тоо ширхэг
	1	2	3	4
1	Тархины цахилгаан бичлэгийн аппарат	БНХАУ	EEG - 81	6
2	Тархины допплер	БНХАУ	EMS-9	6

5. Захиалагч болон нийлүүлэгч байгууллагын зүгээс үл хамаарсан хүчин зүйлсийн улмаас гэрээний зарим зүйл заалт биелүүлэх хугацаа хойшлогдсон тохиолдолд хоёр тал харилцан тохиролцож, зөвшилцэн шийдвэрлэнэ.

6. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Бусад шаардлагатай баримт бичиг;
Тендерийн баталгаа;
Тендер ба үнийн хуваарь;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь;
Баталгаат хугацааны мэдэгдэл /албан тоот/
Гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдэл /албан тоот/

7. Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

8. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

9. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

10. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Эдийн засаг, санхүү, хөрөнгө
оруулалтын газрын дарга

Д.Нарантуяа

Хуулийн хэлтсийн дарга

М.Ганзориг

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Ерөнхий менежер

Ц.Төгөлдөр

Ахлан Нягтлан бодогч

Э.Алтанзул

Хөрөнгө оруулалтын хэлтсийн
дарга

Т.Бямбасүрэн Т.Бямбасүрэн

Хуулийн хэлтсийн гэрээний
мэргэжилтэн

Д.Мөнхцэцэг Д.Мөнхцэцэг

Хөрөнгө оруулалтын хэлтсийн
ахлах мэргэжилтэн

Г.Бат-Эрдэнэ Г.Бат-Эрдэнэ

Хаяг: Эрүүл мэндийн яам, Засгийн
газрын VIII байр, 1 давхар 106 тоот
өрөө Улаанбаатар-48, Олимпын
гудамж-2
Утас: 51-263631, Факс: 323541

Хаяг: Баянгол Дүүрэг, 11-р хороо,
Эх нялхасын гудамж, 21/A байр
Утас: 976-7010-1313
И-мэйл: info@bayangolmed.mn
Дансны дугаар: 475006054
Худалдаа, хөгжлийн банк

ТЕХНИКИЙН КОМИССЫН
УРЬДЧИЛСАН ДҮГНЭЛТ

2020 оны 12 дугаар сарын 18.

№ 98/2020

Улаанбаатар хот

НЭГ.

- 1.1 Гэрээний нэр, дугаар, огноо: Эрүүл мэндийг дэмжих төвд шаардлагатай тоног төхөөрөмж /Мэдрэлийн эмгэгийн оношилгооны тоног төхөөрөмж/ нийлүүлэх гэрээ, №364, 2020 оны 10 дугаар сарын 29-ны өдөр
- 1.2 Тоног төхөөрөмжийн нэр: Багц 2. Мэдрэлийн эмгэгийн оношилгооны тоног төхөөрөмж
- 1.3 Захиалагч байгууллага: Эрүүл мэндийн яам
- 1.4 Нийлүүлэгч байгууллага: "Баянгол мед" ХХК
- 1.5 Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/317 дугаар "Техникийн комисс шинэчлэн байгуулах, журам батлах тухай" тушаалаар томилогдсон ажлын хэсэг нь батлагдсан удирдамжийн дагуу захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний дагуу нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийг гэрээний хавсралт, ерөнхий болон тусгай нөхцөлд тусгагдсан шаардлагыг хангасан байдал, барааны чанар, тээвэрлэлт, хадгалалтын байдал болон тоног төхөөрөмжийн холбогдох баримтуудыг үндэслэн багаж, тоног төхөөрөмжийн марк, модел, техник үзүүлэлт таарч буй эсэхэд шалгаж техникийн комиссын урьдчилсан дүгнэлтийг гаргав.

ХОЁР.

- 2.1 Гүйцэтгэгч байгууллага гэрээний дагуу нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийг 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдөр "Баянгол" ХХК-ийн агуулахын байранд очиж үзсэн бөгөөд баримт бичигтэй тулгалт хийж үзээд, ажлын хэсэг хүлээн авагч эрүүл мэндийн байгууллагуудын ашиглалтад хүлээлгэн өгөхөөр шийдвэрлэв.
- 2.2 Гүйцэтгэгч захиалагчаас өгсөн багаж, тоног төхөөрөмжийг хуваарийн дагуу эрүүл мэндийн байгууллагуудад хүргэж, сууринуулж, ашиглалтын сургалтыг явуулж, 2 жилийн хугацаанд баталгаат засварыг бүрэн хариуцаж, сэлбэг хэрэгслээр хангана.
- 2.3 Техникийн комиссын урьдчилсан дүгнэлт, холбогдох баримт бичиг, материалыг 3 хувь үйлдэж захиалагч, гүйцэтгэгч, хүлээн авагч байгууллага тус бүрт 1 хувийг хүргүүлнэ.
- 2.4 Техникийн комиссын урьдчилсан дүгнэлт нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - Тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт
 - Баталгаат засварын хугацаа, үйлчилгээ, тохиргооны батлагдсан хуваарь

ГУРАВ. БАГАЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ҮНЭ, ТОО ШИРХЭГ

Д/д	Барааны нэр	Барааны гарал үүсэл	Марк, тип	Тоо	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Тархины цахилгааны бичлэгийн аппарат	БНХАУ	EEG-8102	6	24,880,000	149,280,000
2	Тархины допплер	БНХАУ	EMS-9PB	6	49,880,000	299,280,000
НИЙТ						448,560,000
Дөрвөн зуун дөчин найман сая таван зуун жаран мянган төгрөг						

ДӨРӨВ. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Д/д	Гэрээнд тусгагдсан техник үзүүлэлт	Шаардлага хангасан эсэх
1. Тархины цахилгааны бичлэгийн аппарат Үйлдвэрлэсэн улс: БНХАУ Үйлдвэрлэгч: Shenzhen delica medical equipment Co.,Ltd Загвар: EEG-8102 ШААРДЛАГА ХАНГАЖ БҮЙ ЭСЭХ: ТИЙМ	<ul style="list-style-type: none"> ✓ Тархины цахилгаан бичилтийн суваг: 32 сувагтай /Тархины цахилгаан бичлэг хийх үед илүү олон сувгаар бичилт хийх бөгөөд оношилгооны нарийвчлал өндөр/ ✓ Оролтын импеданс: 100мОм ✓ Мэдрэг чанар “Sensitivity”: <ul style="list-style-type: none"> - 0,1–200 μV/mm (21 stages) for EEG and EP - 0,02–5 mV/mm (8 stages) for super-slow potentials - 5–500 μΩ/mm (7 stages) for volume REG; - 0,1–10 Ω/mm (7 stages) for differential REG - 0,1–200 μV/mm (13 stages) for polygraphic channels (modification10) ✓ Нам фазын шүүлтүүр (LPF): 5–70 Гц ✓ Өндөр фазын шүүлтүүр (HPF): 0,016–16Гц ✓ Бичлэг хийх, бичлэгээ эргэж уншиж болно. ✓ Өндөр ба бага давтамжийн артифакт шүүлтүүр, мэдрэмж, бичлэгийн монтажийг бичилт хийх, бичлэгийг эргэж харах үед тохируулах болон сонголт хийж болно. ✓ Сорилуудыг ба артефактыг бичлэг дээр тэмдэглэж болно. ✓ Автомат ба гар ажиллагаатай фотостимулятортой /дан пульс, давхар пульс болон тохиолдлын пульс гэх мэтээр сонгож болно/ ✓ Үр дүнг дэлгэц дээр харах, 50 хүний бичлэг хадгалан эргэж харах, бүх төрлийн принтерт холбогдоно ✓ Дэлгэц дээр электрод тус бүрийн импедансийг шалгана. Мөн Amplifier дээрх импедансыг 2-50кОм-оор шалгана. /Импедансыг шалгах товчлуур дээр даран холболтын импедансыг шалгах бөгөөд холболт тус бүрийн импедансийн хариу ЛЕД гэрлээр amplifier дээр харагдах хялбар функцтэй/ ✓ Бичлэгийг Microsoft office (Word, Power point, Excel) програмууд дээр гаргах, e-mail-ээр илгээж болно. ✓ 3D дүрслэлтэй ✓ Програм хангамж: Комьютерт сууринласан програм хангамжтай ✓ Дэлгэц: 21 инч /Илүү том дэлгэцээр оношилгоог харах, хянах боломжийг олгоно/ ✓ Цахилгаан тэжээл: 220В, 50Гц ✓ Тохирох чадлын UPS-тэй ✓ Зориулалтын ширээтэй. /Түгжигддэг 4 дугуйтай эмнэлэг дотор зөөверлөн ашиглахад хялбар/ ✓ Зориулалтын малгай, малгайд зориулсан цахилгааны кабельтай ✓ Принтертэй 	Хангасан /UPS, принтер байхгүй/
2. Тархины допплер Үйлдвэрлэсэн улс: БНХАУ Үйлдвэрлэгч: Shenzhen delica medical equipment Co.,Ltd Загвар: EMS-9PB ШААРДЛАГА ХАНГАЖ БҮЙ ЭСЭХ: ТИЙМ	<ul style="list-style-type: none"> ✓ 128 хүртэлх гүнтэй оношлогоо, хяналтын горимтой ✓ 750 хүртэлх замтай M-Mode-той ✓ 8 спектрийг нэгэн зэрэг үзүүлдэг 	Хангасан

- ✓ Гавлын ясны нэвтрэлтийн 1.6 МГц-ийн пробтой Доплерограф нь 1.6МГц ба 16МГц (1.6/2MHz, 4MHz, 8MHz, 16MHz) хоорондох давтамжтай, CW/PW сонгох горимтой
- ✓ Дэлгэцэнд харуулах хурд: 750 см/сек
- ✓ /Васоспазмд, Тархины судасны эмгэг, Гемодинамик нөлөө, Гавлын ясны нарийсал ба микроэмболийн дохиог илрүүлэх, тархины судасны реактив, Мэдрэлийн мэс заслын үеийн хяналт, Коротид энтартерэктоми буюу гүрээний стентийн үеийн хяналт, Зүүн зүрхний шунт бүхий өвчтөний foramen ovale оношлогооны програм хангамжтай/
- ✓ Баталгаатай EDS эмболийн илрүүлэлттэй
- ✓ Vasomotoric Response (VMR) модуль, нэмэлтээр нэгдсэн CO2 анализатортай
- ✓ USB холболттой доплер модультай
- ✓ MS Windows® програм хангамжтай. Хяналт тавих олон тооны процесс бүхий англи хэл дээрх програм хангамж
- ✓ Мэдээллийг янз бүрийн формат руу экспортлодог /BMP, JPG, PWG, XML, PDF, DOC, XLC, TXT гэх мэт/
- ✓ DICOM интерфэйстэй. Dicom 3.0-ийг санал болгож байгаа бөгөөд RIS PACS системд холбогдоно (Хадгалах, Ажлын жагсаалт, Хэвлэх)

ТАЙЛБАР, ДҮГНЭЛТ:

1. Эрүүл мэндийг дэмжих төвд шаардлагатай тоног төхөөрөмж /Мэдрэлийн эмгэгийн оношилгооны тоног төхөөрөмж/” нийлүүлэх гэрээ, №364 гэрээний дагуу нийлүүлэгдэж буй 2 нэр төрлийн 12 ширхэг тоног төхөөрөмжийн техник үзүүлэлтийг гэрээнд тусгагдсан үзүүлэлттэй тулгаж үзэхэд бүрэн хангаж байна.
2. Ханган нийлүүлэгч байгууллагын зүгээс:
 - Тархины цахилгааны бичлэгийн аппаратын програм хангамжид шинэчлэл хийж мэдрэг чанарын үзүүлэлтийг гаргах, принтер болон тохирох чадлын UPS байхгүй тул нэмэлтээр авч, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх.
 - Тоног төхөөрөмжийн ашиглалтын болон аюулгүй ажиллагааны зааварчилгааг Монгол хэл дээр бэлтгэн хүлээн авагч байгууллагад өгөх.
 - Гэрээнд заагдсан дагалдах хэрэгслийн тоо ширхэг, нэр төрлийн дагуу хүлээлгэн өгөх.
 - Холбогдох эмч, эмнэлгийн мэргэжилтэнд ашиглалт, аюулгүй ажиллагаа, засвар үйлчилгээний сургалт зохион байгуулах шаардлагатай.
3. Ашиглагч байгууллагын зүгээс:
 - Гэрээнд заагдсаны дагуу тоног төхөөрөмжийн дагалдах хэрэгслийн тоо ширхэг, нэр төрлийн дагуу мөн холбогдох баримт бичиг, мөн техник үзүүлэлтэд тусгагдсан тухайн тоног төхөөрөмжийн програм хангамж, функцийг нэг бүрчлэн хүлээж авах шаардлагатай.

УРЬДЧИЛСАН ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

Техникийн комиссын дарга:

ЭМЯ-ны Эм, үйлдвэрлэл, технологийн газрын дарга  Н.Гэрэлт-Од

Нарийн бичгийн дарга:

ЭМЯ-ны ЭҮТГазрын Эмнэлгийн тоног төхөөрөмж, хэмжлийн нэгдмэл байдлын асуудал хариуцсан  8270975-9987443
мэргэжилтэн

Б.Сансармаа

Гишүүд:

ЭМЯ-ны ЭЗСХОГазрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн

Г.Бат-Эрдэнэ

ЭМХТ, ЭЭТТАлбаны Эмнэлгийн тоног Төхөөрөмжийн бүртгэл, судалгаа, мэдээний Нэгдсэн сан хариуцсан мэргэжилтэн

Б.Батсој

ЭМХТ, ЭЭТТАлбаны Эмнэлгийн тоног засвар үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Б.Санж-Очир

ЭМХТ, ЭЭТТАлбаны Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт баталгаажуулалт хариуцсан мэргэжилтэн Ж.Халиунаа



Ц.Төгөлдөр

Ц.Ууганбаяр

ЗӨВШӨӨРСӨН:

“Баянгол Мед ХХК” компаниййн ерөнхий менежер

“Баянгол Мед ХХК” компаниййн ахлах инженер